

4

ТӨРӨӨС ЭДИЙН ЗАСГИЙГ ЗОХИЦУУЛАХ НЬ

Т.Дорж

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн харилцаанаас зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж буй өнөө үед манай улсын эдийн засгийн тогтолцоо нь Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлд зааснаар Монгол улс дэлхийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна. Өмнөх тогтолцооны үед өмчийн төрлийг дотор нь улсын, хоршооллын, амины хэмээн дугаарлан авч үздэг байсан тэгш бус байдлыг өөрчлөн төрөөс улсын болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрсөн өмчийн эрхийг хуулиар хамгаалж байна. Ингэснээр өнөөдөр хувийн улсын бас бусад өмч хосолсон холимог эдийн засгийн тогтолцоо бүрдээд байна.

Өнөө үеийн төрийн болон хоршооллын өмчийг задалж хувьчилсан хувьчлалаар болон шинээр хувийн аж ахуйн нэгж үүсгэх замаар нийт өмчид хувийн өмчийн эзлэх хувийн жин ихсэж өмчийн бүх хэлбэр тэгш эрхтэй зэрэгцэн оршиж байна.

Монгол улсын Татварын Ерөнхий Газрын мэдээгээр 1996 оны 1-р сарын байдлаар МУ-д 20-иод мянган аж ахуйн хэвшил бүртгэгдээд байгаа нь нийт аж ахуйн 80% болж байна. Нийт үндсэн капиталын 20 орчим хувь, нийт ажиллагсадын 30 гаруй хувь нь хувийн хэвшилд харъяалагдаж байна. Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд 1996 оны эхний байдлаар ДНБ-ний 63.8% үйлдвэрлэдэг боллоо.

Төрөөс эдийн засгийн амьдралд аль хэр оролцох нь хэзээнээс маргаантай асуудал байсан бөгөөд хоёр туйлшралын хооронд хэрэгжиж иржээ. Эдгээрээс эхний хязгаар нь төрөөс эдийн засгийг бүхэлд нь захиргаадан удирдах төвлөрсөн төлөвлөгөөт удирдлагын систем юм. Нөгөө хязгаар нь төрөөс эдийн засгийн үйл ажиллагаанд оролцохгүй тэр нь зөвхөн зах зээлийн эдийн засгийн механизмаар өөрөө өөрийгөө удирдан хөгжих тухай үзэл баримтлал билээ. Сүүлчийнх буюу өөрөөр хэлбэл нийгэм эдийн засгийн амьдралыг зөвхөн зах зээлийн эдийн засгийн механизмаар зохицуулна, харин төр түүнд саад болохгүй гэсэн сонгодог эдийн засгийн үзэл баримтлал явцгүй болохыг нийгэм эдийн засгийн амьдрал батлан харууллаа.

Тухайлбал, түүхэн хөгжлийн явцад төрөөс иргэдийнхээ өмнө хүлээх үүрэг хариуцлага өргөжин ялангуяа энэ зууны 20-30 оны заагт дэлхийг хамарсан "Их хямрал" зохицуулалтгүй зах зээлийн эдийн засгийн механизмын үйлчлэл хичнээн ширүүн үр дагаварт хүргэж болохыг харуулсан нь эдийн засагт төр чухал үүрэгтэйг нийтээр хүлээн зөвшөөрөхөд хүргэсэн юм.

Дан захиргаадалтын аргаар биш дан зах зээлийн механизмаар биш харин тэр хоёрыг зохистой хослон ашиглах замаар төрөөс эдийн засагт нөлөөлөх нь зохистой болохыг дэлхийн олон судлаачдын судалгааны үр дүн батлан харуулж байна. Дэлхий нийтийн бараг бүх орон холимог эдийн засагтайг тэмдэглэх нь зүйтэй. Манай орон ч холимог эдийн засагтай билээ.

МУ-ын Үндсэн хуулийн нэгдүгээр бүлгийн тавдугаар зүйлд "Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлсэн эдийн засгийг зохицуулна" гэж заажээ.

Улс орнуудын эдийн засгийн өөрийн өвөрмөц онцлогоос шалтгаалан эдийн засагт төрийн болон зах зээлийн механизмын оролцоо ялгаатай байна. Үүнийг тоон үзүүлэлтээр илэрхийлэх явдал хүндрэлтэй ч зарим орны эрдэмтдийн судалгааны үр дүнгээс үзэхэд зах зээлийн харилцаа илүү хөгжсөн орнуудын хувьд ҮНБ-ний 4/5-ийг зах зээлийн механизмын, 1/5-ийг төрийн оролцоотойгоор тус тус үйлдвэрлэж байна гэж үздэг.

Төр улсын үйлдвэрийн үйл ажиллагааны санхүүжилтэнд анхаарахын зэрэгцээ нийгэм хангамжийн программыг боловсруулж хувийн секторт орлогын дахин хуваарилалт хийх зорилгоор авч хэрэгжүүлдэг.

Манай орны хувьд төрийн захиргааны болон нийгэм хангамжийн зардал ҮНБ-ний 30 гаруй хувийг эзэлж байна. Үүний зэрэгцээ төрөөс байгаль орчныг хамгаалах, хүний эрүүл мэндэд хор учруулах бүтээгдэхүүний үйлдвэрлэлээс хэрэглэгчийг хамгаалах ажлын байр бий болгож ажилгүйдэл ядуурлыг багасгаж суурь хавсарга шинжлэх ухаан, соёл боловсролыг хөгжүүлж эрүүл мэндийг хамгаалах гэх зэрэг тоон үзүүлэлтээр тодорхойлоход түвэгтэй олон арга хэмжээг авч явуулдаг. Эндээс төрийн эдийн засагт гүйцэтгэх үүрэг хичнээн буй нь тодорхой.

Ингэхдээ төр захиргаадалтын шууд аргаар бус зах зээлийн эдийн засгийн арга механизмийг ашиглан нөлөөлж зохицуулах жамтай.

Төр эдийн засагт ямар үүрэг гүйцэтгэвэл улс орон илүү хурдацтай хөгжих вэ? Эдийн засгийг зуураад авчихвал хөдөлдөггүй, зах зээлд сул тавьчихвал бас болдоггүй, харин төр нь зах зээлийн эдийн засгийн механизмийг оновчтой ашиглаж илүүтэйд үзэж хэрэглэгч үйлдвэрлэгчдийг хооронд нь зохистой уян хатнаар холбож чадсан улс орон илүү хурдацтай хөгжиж байна.

Энэ талаар олон судлаачид олон санал бодолтой байна. Бидний судалгаагаар дээрээс нь төвлөрүүлж удирдах захиргаадалтын эдийн засгийн тогтолцооноос

төрийн хязгаарлагдмал үүрэг гүйцэтгэдэг зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж байгаа өнөө үед төрийн зүгээс эдийн засагт доорхи үүрэг гүйцэтгэх учиртай. Үүнд:

1. Төрийн эдийн засгийн зарим зорилт нь зах зээлийн тогтолцоо хэвийн ажиллах нөхцлийг бүрэлдүүлж, улмаар түүний ажиллагааг хангахад оршино. Иймээс зах зээлийн тогтолцоог үр ашигтай ажиллах чухал нөхцөл болсон хууль эрхзүйн үндсийг бүрдүүлж хэрэгжих нийгмийн орчинг бүрдүүлэх үүргийг хүлээнэ.
2. Өрсөлдөөнийг хамгаалан дэмжих.
3. Орлого баялгийг дахин хуваарилах.
4. Үндэсний бүтээгдэхүүний бүтцийг өөрчлөх зорилгоор нөөцийн хуваарилалтыг зохицуулах.
5. Эдийн засгийг тогтворжуулах эдгээр болно.

Дээрх төрийн үйл ажиллагааг тодруулъя.

1. Төр эдийн засгийг журамлан зохицуулагч. Эдийн засгийг журамлан зохицуулахад зах зээлийн эдийн засаг үр ашигтай ажиллах урьдчилсан нөхцөл болсон хууль эрхзүйн үндэс бүрдүүлж зарим чухал үйлчилгээгээр хангах үүргийг төр гүйцэтгэх учиртай билээ. Зайлшгүй шаардлагатай эрх зүйн үндсийг бүрдүүлэх нь хувийн үйлдвэрүүдэд хуулийн статус олгох хувийн өмчийн эрхийг тодорхойлж гэрээ контрактын хэрэгжилтийг баталгаажуулах боломж олгохын дээр зах зээлийн тогтолцооны дотоод үйл ажиллагааг өрнүүлэх, аж ахуйн нэгжүүд, бэлтгэн нийлүүлэгчид хэрэглэгчдийн хоорондын харилцааг зохицуулахаа эдийн засгийн хүрээнд төр арбитрайн үүргийг бас гүйцэтгэх бөгөөд эдийн засгийн хувьд шударга бус үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжийг шийтгэх ч арга хэмжээг авна. Тэрчлэн төрөөс үзүүлэх үндсэн үйлчилгээнд нийгмийн хэв журмыг хангах цагдаагийн хүчийг ашиглах бүтээгдэхүүн ажил үйлчилгээний чанар стандартыг хангах, мөнгөний тогтолцоог бүрдүүлэх зэрэг үүргүүд багтана.

2. Төр өрсөлдөгчийг дэмжинэ. Төрийн хийх ёстой ажил бол өрсөлдөөнийг дэмжиж, өрсөлдөөний орчинг бүрдүүлэх явдал юм. Учир нь зах зээлийн эдийн засагт өрсөлдөөн нь зохицуулагч үндсэн механизм нь болж өгнө. Энэ нь үндсэндээ худалдан авагч, хэрэглэгчдийн эрх ашигт нийцүүлсэн бэлтгэн нийлүүлэгч үйлдвэрлэгч нарыг захиран зохицуулах хүч болно.

Өрсөлдөөний үед эрэлт нийлүүлэлтийн хэрэгцээний тухай олон худалдан авагч худалдагч нарын шийдвэр нь үндсэндээ зах зээлийн үнийг тодорхойлж өгдөг. Энэ нь нөөц ресурсийг үйлдвэрлэн нийлүүлэгчдэд нь хэрэглэгчдийн хүсэл эрмэлзлэлд дасан зохицно гэсэн үг. Гэхдээ энэ үйл ажиллагаа зах зээлээр дамжин явагдана.

Өрсөлдөж буй үйлдвэрлэгчид зах зээлийн тогтолцооны хүсэл зоригт захирагдахын дээр тэд ашигтай ажиллаж өөрсдийн байр сууриа бэхжүүлэхийн төлөө байх бөгөөд хэрэв зах зээлийн хууль зүйг зөрчвөл дампуурах аюултай учирдаг.

Өрсөлдөөний үед худалдан авагчид бол эзэн, зах зээл бол тэдний агент, үйлдвэрлэгчид бол тэдний зарц нар байх учиртай. Монополийг өсөлт энэ байдлыг дор нь өөрчилдөг. Монополь гэж юу вэ? өргөн утгаараа бол энэ нь цөөн худалдагчдаас худалдагч бүр нийт эрэлтэд нөлөөлж чадах буюу худалдаж буй таваарын үнэнд нөлөөлж буй нөхцөл байдал юм. Ийм нөхцөл байдлын утга учир юунд орших вэ? гэвэл өрсөлдөөнийг монополиор сольж худалдаачид зах зээлд нэг үгээр хэлбэл өөрсдийн эрх ашигт нийцэхээр үнэнд нөлөөлж энэ байдал нь нийгэмд хор уршиг авчирдаг.

Монополь эрх эдлэгчид зах зээлд бага зүйл үйлдвэрлэж түүнийгээ өндөр үнээр худалдаж их ашиг олохын тулд монополь эрх эдлэгчдийн хувь ашигтайгаар хуваарилагддаг. Ийм монополийн үйл ажиллагаанд төрөөс хяналт тавих учиртай. Манай орны хувьд цахилгаан дулаан, усан хангамж, тээвэр холбоо зэрэг нь техник технологи, эдийн засгийн хувьд /байгалаас заяасан/ монопольт чадвараа алдаагүй байна. Иймд төрийн зүгээс үнийг хянах шаардлагатай гэж үзэж байна.

3. Төр орлогыг хуваарилагч. Зах зээлийн тогтолцоо хайрлаж өрөвдөхийг мэдэхгүй өршөөлгүй хатуу ширүүн механизмийг өөртөө агуулж байдаг. Орлогыг хуваарилалтын явцад нийгмийн хүсэн хүлээж байгаагүй хэмжээний тэгш бус байдал үүсдэг.

Зах зээлийн тогтолцоо нь ажлын өндөр чадвар, арга барилтай өндөр боловсролтой авъяастай хүмүүст хэмжээлшгүй их орлого олох боломжтой болдог. Өөрсдийн эх эцэг ах дүү төрөл төрөгсдөөсөө өвлөн авсан газар, үйлдвэрлэл, байшин барилга бусад эд хөрөнгө мөнгөтэй хүмүүс илүү их орлоготой байдаг.

Харин хөдөлмөрийн чадварын хувьд өндөр биш бага боловсролтой урьдах үеэсээ өвлөн авсан хөрөнгөгүй бага орлоготой хүмүүс, тэрчлэн өндөр настай, тахир дутуу, оюун ухааны хувьд доголдолтой хүмүүс зах зээлийн тогтолцоонд орлого олох боломжгүй билээ. Ингэхлээр мөнгөн орлого хуваарилалтын хүрээнд зах зээлийн тогтолцоо тэгш бус байдалд оруулдаг нь тодорхой.

Зах зээлийн тогтолцоо зарим талаар хөгжил дэвшил авч ирдэг ч түүнийг ядуурал дагалддаг учраас нийгэм эдийн засгийн хувьд хурц асуудал үүсдэг жамтай. Ийм учраас төр өөртөө орлогын тэгш бус байдлыг багасгах үүрэг хүлээдэг. Энэхүү үүргээ нийгэм хангамжийн хөтөлбөр, татварын тогтолцоогоор дамжуулан хэрэгжүүлдэг.

4. Төр нөөцийг дахин хуваарилагч. Өнөө үед зах зээлийн дотоод ажиллагааг зөрчилд оруулдаг хоёр тохиолдол байдаг. Өрсөлдөөний зах зээлийн нөхцөлд энэ нь тодорхой нэг төрлийн бүтээгдэхүүн ажил үйлчилгээг байвал зохих хэмжээнд нь хүргэж үйлдвэрлээгүйгээс эсвэл эдийн засгийн хувьд ашигтай зарим төрлийн бүтээгдэхүүн ажил үйлчилгээг явуулахад тодорхой хуваарилан гаргах нөөцийн хомсдол гарсанаас болж үүсдэг байна.

Эхний тохиолдол нь нөөцийн гадагшлах урсгалтай холбоотой байдаг. Энэ нь шууд

биш үр ашиг болон улс нийгмийн баялаг түүхтэй холбогдож үүсдэг.

Өрсөлдөөнт зах зээлийн нэг онцлог нөөцийг үр ашигтай хуваарилахад боломж бүрдүүлдэг. Нэг үгээр хэлбэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл ажил үйлчилгээнд нөөц ашигтайгаар зөв хуваарилагдана гэсэн үг.

Зах зээл нөөцийн ашигтай хуваарилалтыг өөрөө зохицуулж, улмаар бүтээгдэхүүн ажил үйлчилгээ бүрийн үйлдвэрлэлтэй холбогдох зардал ашиг нь зах зээлийн эрэлт нийлүүлэлтэнд тусгалаа олдог. Ингэхээр бүтээгдэхүүн ажил үйлчилгээ бүрийн үйлдвэрлэлтэй холбоотой нөөцийн илүүдэл урсгал гарч шууд бус ашиг үүсэхгүй нь тодорхой. Бүтээгдэхүүн ажил үйлчилгээний үйлдвэрлэл, хэрэглээтэй холбогдсон зардал ашиг үйлдвэрлэгч, хэрэглэгчтэй ямар ч холбоогүй гурав дахь этгээдэд хуваарилагдан шилжих үед нөөцийн илүүдэл урсгал үүсэх бөгөөд үүнийг шууд бус үр ашгийн нөөцийн гадагшлах урсгал ч гэж нэрлэдэг. Хэдийд бүтээгдэхүүний үйлдвэрлэл хэрэглээ нь түүнтэй холбоогүй 3 дахь этгээдэд нөхөж төлөгдөхгүй зардлыг хуваарилаж байна вэ? тэр нь зардлын гадагшлах урсгал юм. Үйлдвэрлэлийн хаягдлаас болж байгаль орчин бохирддог. Үүний тод жишээ нь газрын баялагийг ашиглаад хөрсний эвдрэл их ч, хэн ч хэрэгсэхгүй байна. Улаанбаатар хотод үйлдвэрийн болон гэр хорооллын утаа нь заримдаа хүн амьсгаалахад нэн бэрхтэй болгодог. Энэ мэтийн зүйлсийг төрөөс зохицуулах учиртай. Үүнийг зохицуулах хоёр арга байх болов уу гэж үзнэ.

Нэгдүгээрт: үйлдвэрлэлийн гадагшлах зардал буюу хаягдлаар байгаль орчныг бохирдуулахгүй байх талаар хууль гаргаж хэрэгжүүлэх. Ингэвээс бохирдуулсан байгаль орчноо буцааж хэвийн хэмжээнд хүргэхэд зардал гаргах ёстой.

Хоёрдугаарт: Онцгой татварын арга юм. Нэгж бүтээгдэхүүнээс байгаль орчинд учруулж буй хохирлын хэмжээтэй тэнцэх хэмжээний онцгой татварыг засгийн газраас тогтоож хэрэгжүүлнэ.

Илүүдэл зардлын урсгалын үр ашгаар зохицуулах: илүүдэл зардлын урсгал зарим тохиолдолд ашигтай ч байдаг. Зарим бүтээгдэхүүн ажил үйлчилгээний үйлдвэрлэл хэрэглээний хувьж буцаж нөхөгдөхгүй илүүдэл зардал нийгэм, хамт олонд ашиг өгч авч ирэх нь бас бий. Үүний тод жишээ бол- боловсрол: тодорхой хэрэглэгчийн хувьд боловсрол үр өгөөжтэй байдаг. Өндөр боловсролтой хүмүүс бага боловсролтойг бодвол илүү бүтээлч, бас их ашиг орлого бий болгодог.

Нөгөө талаар боловсрол өндөр байвал хэрэг зөрчилд орооцолдохгүй. Хэв журам сахиулахад зориулж улсаас илүү мөнгө зарахгүй байх жишээтэй.

Энэ асуудлыг төрөөс яаж зохицуулах вэ? Эрэлтийг ихэсгэхэд илүүдэл зардлын урсгал ашигтай байх тийм бүтээгдэхүүн ажил үйлчилгээний эрэлтийг ихэсгэх явдал юм.

Бага орлоготой хүмүүсийн хүнсний хэрэглээний бүтцийг сайжруулахад зориулсан талон гаргаж болно. Ийм талоныг ЗГ-аас бага орлоготой хүмүүст олгож тэд

дэлгүүрээс хүнсний бүтээгдэхүүнийг талноор авснаар тэдний хүнсний хангамж сайжирна. Ингэснээр ядуу зүдүү амьдралтай хүүхдүүд сайн суралцах, ажлын чадвартай хүмүүс нь сайн ажиллах бололцоотой болно. Энэ нь нийгэмд тийм хэмжээний ашиг авчирна.

Нийлүүлэлтийг ихэсгэж хэрэглэгчдийг тодорхой нэг төрлийн бүтээгдэхүүнээр хангах замаар зохицуулалт хийдэг. Иймийн тулд үйлдвэрлэгчдэд ЗГ-аас тэтгэн дэмжих байдлаар татвар ногдуулах юм. Ингэснээр энэ нь дээд боловсрол, эмнэлэг, сувилал зэрэгт тэтгэмж олгох боломж олдоно.

ЗГ халамжлах зардлын илүүдэл урсгалын өгөөж өндөр байвал ЗГ түүнийг санхүүжүүлэх нэг үгээр хэлбэл төрийн өмч болгон түүнийг шууд удирдана.

Нийгмийн баялаг үйлчилгээгээр зохицуулах нь. Зарим цөөн нэр төрлийн бүтээгдэхүүнийг цөөн тоогоор хэрэглэдэг ч түүнээс нийгэмд өгөх үр өгөөж өндөр байдаг. Тухайлбал томоохон хотуудын байшин барилга дээр цагууд байдаг. Энэ нь хүмүүс ажил төрлөө зохицуулахад ач холбогдолтой. Бэлчээрийг үлийн цагаан оготноос хамгаалах, элсний нүүлтийг зогсоож газраа хамгаалах гэх зэргийг зохицуулах нь олон талын ач холбогдолтой. Хорт шавьжийг устгах нь нийгмийн хувьд бас ач холбогдолтой ч эдгээрийг хувийнхан сонирхдоггүй.

Нийгмийн баялаг бол батлан хамгаалах явдал байдаг. Төрийн зүгээс хамгаалж санхүүжүүлж үйлчилж байх нийгмийн баялаг, үйлчилгээ байх учиртай.

Улс оронд гудамж талбай, авто зам цагдаа, гал команд номын сан музей гэх зэрэг төдий нийгмийн, баялаг үйлчилгээнүүд бий. Энэ зах зээлээр шууд зохицуулах боломжгүй төрөөс удирдах үйл ажиллагааг заавал шаарддаг. Ийм учраас төр дээрх зүйлийн үйлдвэрлэл санхүүжилтийг өөртөө авч явдаг.

5. Эдийн засгийн тогтворжуулалт. Эдийн засаг дахь тэнцвэрт бус байдал нь нийт эрэлт, нийт нийлүүлэлтийн өөрчлөлтөөс болж үүсдэг. Зах зээлийн эдийн засгийн харилцааны нөхцөлд төрийн нэг гол үүрэгт ажил эдийн засгийг тогтворжуулахад оршино. Өөрөөр хэлбэл төрөөс эдийн засгийн хувийн сектор анхааран тусалж бүрэн ажил эрхлэлтийг хангаж тогтвортой үнийн түвшинг төлөвшүүлэх гэсэн үг юм. Төрөөс эдийн засгийг тогтворжуулах үүргээ гүйцэтгэхэд зардлын бодлого чухал үүрэгтэй. Үйлдвэрлэлийн түвшин зардлын хэмжээнээс шууд хамаарна. Хэрэв зардал өндөр байна гэдэг нь бол тийм салбаруудын хувьд бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх ашиглалт өндөр байх учиртай. Зарим эдийн засагчид зах зээлийн эдийн засгийн харилцааны зардлыг нэмэгдүүлэх замаар бүрэн ажил эрхлэлтийг хангах тийм механизм байхгүй гэж үзэж байна. Энэ байдал нь ажилгүйдэл инфляцид хүргэх ёстой гэж тэд үздэг. Ингэж үздэг ч бас бүрэн ажил эрхлэлтийг хангах арга бий гэж үзэх явдал байдаг.

Хувийн хэвшлийн нийт зардал хөрөнгөөр бүрэн ажил эрхлэлтийг хангах боломжгүй. Ийм нөхцөлд төр хувийн секторын хөрөнгө зардлыг төрийнхтэй нийлүүлэх замаар бүрэн ажил эрхлэлтийг хангах боломжтой. Үүнийг төр яаж хийж чадах вэ? гэвэл

нийгмийн баялагийн үйлдвэрлэлд зориулж нөөцийг дахин хуваарилахад ашигладаг арга болох төрийн зардал болон татварын нийлбэр байх юм. Ингэхдээ нэг талаас төр нийгмийн баялаг үйлчилгээнд зориулагдах зардлаа нэмэгдүүлэхийн зэрэгцээ нөгөө талаас хувийн секторыг урамшуулах зорилгоор татвараа багасгах юм. Эдийн засгийнхаа хүчин чадлаас илүү зардал гаргах гэж нийгэм чармайх юм бол түвэгтэй байдал үүсдэг. Бүрэн ажил эрхлэлтийн үед ч нийт нийлбэр зардал бүтээгдэхүүнийхээ хэмжээнээс давах юм бол илүүдэл зардал үнийг өсгөхөд хүрнэ. Эндээс нийт зардалын гэнэтийн өсөлт ханшгүйдлийг төрүүлдэг жамтай. Энэ үед төр илүү зардлын гэнэтийн өсөлтийг заавал арилгах учиртай бөгөөд ийм үед төр өөрийнхөө зардлыг багасгах хувийн секторын зардлыг багасгах зорилгоор татвараа нэмэгдүүлэх нь илүү тохиромжтой. Ийм байдлаар зохицуулахдаа мөнгө санхүү төсөв, татварын холбоотойгоор үйлчлэх учиртай. Энэ бүгдийг хооронд нь холбон уялдуулсан санхүүгийн программыг макро түвшинд боловсруулан хэрэгжүүлэх нь төрөөс эдийн засгийг удирдах нэг арга болов уу.